



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/259

Хэрлэн сум

Бүсийн уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боржигон ажнай Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбоо төрийн бус байгууллагаас ирсэн хүсэлтийг үндэслэн бүсийн уралдааны товыг хавсралтаар баталсугай.

2. Бүсийн уралдааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Боржигон ажнай Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбоо төрийн бус байгууллагын тэргүүн (Б.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг уралдаан зохион байгуулагдах Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Д.Батхүү)-д, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат), Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 26-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Аймгийн өмнөд бүсийн шилдэг хүлэг
шалгаруулах уралдаан

№	Бүсийн уралдаан зохион байгуулах сум	Огноо	Бүсийн нэр	Уралдах нас
1	Бор-Өндөр	2023.06.17	Өмнөд бүс	Азарга, Их нас